

### Хуваарь шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/918 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, “Нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжих жил”-ийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, иргэдийн аж төрөх эрүүл аюулгүй, амар тайван орчин нөхцөлийг бүрдүүлэх, иргэд, хүүхэд залуучууд, ахмад настан, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог хангах өрх рүү чиглэсэн олон талт ажлуудыг санаачлан зохион байгуулж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас хороодтой хамтран ажиллах холбогдох удирдах албан тушаалтнуудтай уялдаа холбоотой ажиллахыг Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар болон хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2018 оны А/98 дугаар захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг хянан ажиллахыг Засаг даргын Орлогч /Ж.Лхагвасүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ